



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 91 оны 12 сарын 24

№ 362

Улаанбаатар
хот

Улсын үйлвэрийн газар бай-
гуулах тухай

БНМАУ-ын "Аж ахуйн нэгжийн тухай" хуулийг үндэслэн
Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Автобусны 2-р баазыг татан буулгаж Автобус-Ц компани
/УУГ/ байгуулсугай.
2. Автобус-Ц компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Дүрмийн санг 16252511 төгрөгөөр баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА
ХЭРЭГ ЭГХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Handwritten signature]
[Handwritten signature]

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэт-
гэх захиргааны 1991 оны 368 тоот тог-
тоогийн хавсралт.

АВТОБУС-II КОМПАНИЙН ДҮРЭМ

1.Автобус-II компани төрийн өмчийн хэлбэртэй оршин тогтнож байгаа аж ахуйн биеэ даасан нэгж мөн.

2.Автобус-II компанийн зорилго нь нийслэлийн хөдөлмөрчийн зорчигч тээврийн үйлчилгээг соёлч шуурхай хангахад оршино.

3.Автобус-II компани нь өөрийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай эрэлт хэрэгцээг хангахад гадаад харилцаа, худалдааны эрх эдэлнэ.

4.Тус компани нь өөрийн үйл ажиллагаагаа явуулахын тулд банкинд харилцах данстай байхын хамт бусад төр аж ахуйн байгууллага, хувь хүмүүстэй бие даасан гэрээ хэлэлцээр байгуулж ажиллах, хуулийн этгээд байна.

5.Автобус-II компани нь бүхийл үйл ажиллагаандаа хууль тогтоомж, сахилгыг нарийн чанд сахин биелүүлж, өөрт олгогдсон эрхээ төрийн болон хамт олныхоо сонирхолд нийцүүлэн амиллана.

6.Автобус-II компанийг татан буулгах, шинээр еорчлон зохион байгуулахыг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

7.Автобус-II компани нь улсын бүртгэлд бүртгүүлж Октябрийн нүүдгийн нутаг дэвсгэрт байрлана.

8.Автобус-II компани нь тогтоосон журмаар хийсэн тэсдэг, бичгийн нүүр, тушаал, албан бичгийн баланстай байж нягтлан бодохын тайлан тэнцэл гаргаж байна.

Хоёр. Эд хөрөнгө

1.Автобус-II компанийн хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Тус компани нь эд хөрөнгөө БНМАУ-ын хууль тогтоомж болон дүрэмд нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин ашиглаж захиран зарцуулна.

2.Тус компанийн хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр нь амил үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого, улсын төсвийн хөрөнгө, бүх төрлийн зээл бусад эх үүсвэр байна.

Гурав. Шугамн үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаа

1.Тус компани нь үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаагаа байгуулсан гэрээний үүргийн дагуу зорчигч тээврийн өөрийн өртгийг хямдруулж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн явуулна.

2.

2.Тус компани нь Автобусны үйлчилгээг батлагдсан чиглэл, маршрут, цагийн хуваарь графикийн дагуу явуулан үйлчилгээний жигд амжилтааг хангана. Үйлчилгээний чиглэл маршрут шинээр нээх, хаах үйлчилгээг үр ашигтайгаар өөрчлөн зохион байгуулах саналаа боловсруулан удирдах дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх үүрэгтэй.

3.Тус компани нь автобусны үйлчилгээний талаар үйлчилж байгаа газар нутгийн хөдөлмөрчлийн эрэлт хэрэгцээг байнгн судалж талентэй өргөн харилцаатай ажиллана.

4.Компани нь өөрийн санхүүгийн нөөцийг хэ нэлттэйгээр зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн бие-лүүлж удирдах дээд байгууллагатайгаа байгуулсан гэрээгээ цаг хувацаанд нь дүгнэж, тогтоосон дүрмйн дагуу эд хөрөнгийн тоол-лого явуулна.

5.Компани нь цагтлан бодоханхан шатны болон статистикийн бүртгэлийг үнэн зөв хөтлөж бүртгэл тооцооны амилд дэвшилтэд арга барил, техник хэрэгсэл нэвтрүүлэн мэдээ тайлан тэнцлийг батлагдсан маягтаар гаргаж зохих дээд байгууллагад өгч байна.

6.Тус компани нь тогтоосон нсрм нормативыг үнцэслэн тех-никийн засвар үйлчилгээний нарийвчилсан графикийн дагуу өөрийн хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн үйлчилгээнд оруулж урсгал зас-варыг цаг хувацаанд нь шуурхай засварлаж байна.

7.Хүн тээврийн үйлчилгээнд онцгой амжилт гаргасан хүмүүст шагнуулах саналаа дээд байгууллагад уламжилна.

8.Тус компани нь орчноо бохирдуулахгүй байх, түүний бүх талын арга хэмжээг авна.

Дөрөв. Автобус-1 компаний зүх

1.Хэрэгцээтэй түүхий эд, материалыг зохих газраас нь авч түүний ашиглалт зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

2.Тус компани нь банкн дахь зарлагын хансаар ажилчин, албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшил олгох гүйлгээ хийнэ.

3.Ажилчин, албан хаагчдын эзэмшилд байгаа эд хогшлыг кар-таар зохих эзлэд нь хариуцуулан хяналт тавина.

4.Тус компани нь хууль тогтоомжинд заасны дагуу ажил мэргэ-жил хөслөх буюу албан тушаал хавсран ажиллахыг зөвшөөрөх, онцгой тохиолдолд ажилчин, албан хаагчдын хүсэлтийг харгалзан чөлөө олгох, нэг сарын цалингаас хэтрүүлэхгүйгээр урьдчилгаа олгох эрхтэй.

3.

Тав. Удирдлага зохион байгуулалт.

1. Тус компанийн захиралыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа гэрээний үндсэн дээр томилно.

2. Компанийн захирал нь баазын бүх ажлыг зохион байгуулж түүний хөгжил, үйл ажиллагааны үр дүнг бүрэн хариуцна. Захирал нь бүх дээд шатны болон бусад газруудтай компаниа төлөөлөн харилцаж түүхий эд, хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрх хэмжээнийхээ дотор тушаал, заавар гаргах, хөдөлмөрийн хуулийн дагуу ажилчин, албан хаагчдыг ажилд авах, халах тэтгээрийг шагнаж урамшуулах, тэтгэмж тусламж олгох, сахилта батын арга хэмжээ авах эрхтэй.

3. Компанийн захиргаа нь дэргэдэх Үйлдвэрчний эвлэлүүдтэй харилцан тохиролцож хамтран хамтын гэрээ байгуулж, уг гэрээний үүргээ цаг тухайд нь биелүүлэн ажиллана.

4. Тус компанийн захиргаа нь хөдөлмөрийн дотоод дүрмээ батлах, өөрчлөх, шагнал болон нийгэм соёлын арга хэмжээний фондыг тогловлон батлах түүнээс ажиллагсаныг шагнах бусад хөнгөлөлт олгох эрхтэй.

-----oCo-----